



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/115

Зуунмод сум

Зардал гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 7 дугаар хуралдааны 03 тоот тогтоол, Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 239 тоот тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Соёлын байгууллагуудын 2022 оны орон байрны ашиглалттай холбоотой үйлчилгээний ажилчдын 1-2 сарын цалинд шаардагдах 78,515.7 (далан найман сая таван зуун арван таван мянган долоо) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг дарга ерөнхий данснаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

2. Соёлын байгууллагуудын 2022 оны үйлчилгээний ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд шаардагдах хөрөнгийг сумын орон нутгийн төсвийн зарлага хооронд зохицуулалтыг хийж, зардлыг батлагдсан санхүүгийн дэмжлэгт багтаан санхүүжүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю. Бямбацогт)-т даалгасугай.

3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахыг Соёлын байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР